**ЗАГВАР**

**БАТЛАВ**
**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА**
**БӨГӨӨД ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА**
**Д.НАЯНБАЯР**

**......... оны ..... дүгээр сарын ......**

# НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА,
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА Э.БАТБАЯР

**БОЛОВСРУУЛСАН:**
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН
ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ХОШУУЧ Г.ГАНБАЯР

**2026 ОН**

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

| № | Төлөвлөгөөг тодотгосон албан тушаалтан, овог нэр | Тодотгол хийсэн он, сар, өдөр | Хуудасны дугаар | Мөрийн дугаар | Тодотгол хийсэн товч утга |
|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | |
| 2. | | | | | |
| 3. | | | | | |
| 4. | | | | | |
| 5. | | | | | |
| 6. | | | | | |
| 7. | | | | | |
| 8. | | | | | |
| 9. | | | | | |
| 10. | | | | | |
| 11. | | | | | |
| 12. | | | | | |
| 13. | | | | | |
| 14. | | | | | |
| 15. | | | | | |
| 16. | | | | | |
| 17. | | | | | |
| 18. | | | | | |

**АГУУЛГА**


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Төлөвлөгөөний үндэслэл

1.2. Зорилго

**1.3. Зорилт**

1.4. Зарчим

1.5. Хамрах хүрээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах.

2.3. Гамшгаас хамгаалах сургалт.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ

3.2. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүтэц

3.3 Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт

ДӨРӨВ. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ:

4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг байгууллагуудад дамжуулах:

4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:

ТАВ. ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Гамшгийн нийтлэг хариу арга хэмжээ, удирдлага зохицуулалт:

5.2. Байгууллагуудын түвшинд авч хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ:

5.3 Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээ

5.4 Үерийн хариу арга хэмжээ

5.5 Ой хээрийн гал түймрийн гамшгийн хариу арга хэмжээ

5.6 Хүчтэй салхи, шуурганы гамшгийн хариу арга хэмжээ

5.7 Зудын гамшгийн хариу арга хэмжээ

5.8.Уул уурхайн ослын хариу арга хэмжээ

5.9. Химийн ослын хариу арга хэмжээ

ЗУРГАА. ХАНГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ДОЛОО. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

НАЙМ. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

8.1. Хүмүүнлэгийн тусламжийн удирдлага зохицуулалт

8.2. Орон нутгийн нөөцийн зохион байгуулалтын арга хэмжээ

8.3. Дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ

ЕС. ТӨСӨВ, САНХҮҮ

АРАВ. БУСАД

ХАВСРАЛТ

- Дүүргийн танилцуулга
- Дүүргийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний тойм судалгаа /эрсдэлийн үр дүнг оруулах/
- Зарлан мэдээлэл дамжуулах схем
- Зарлан мэдээллийн дууд дохионы судалгаа
- Онцгой комиссыг томилсон захирамж
- Шуурхай штаб байгуулах тухай захирамж
- Бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, цуцлах тухай захирамжийн төсөл
- Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай захирамжийн төсөл
- Хүч хэрэгсэл дайчлан гаргах захирамжийн тухай төсөл
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн судалгаа
- Түр цугларах талбайн судалгаа, зураглал
- Түр орон байрны судалгаа
- Нисдэг тэрэг буух талбайн байршил, зураглал
- Нүүлгэн шилжүүлэх талбайн байршил, зураглал
- Гамшгийн болон орон нутгийн нөөцийн судалгаа
- Нийгмийн хариуцлагын гэрээ
- Сайн дурын хэсэг томилсон шийдвэр

### 1.1. Үндэслэл

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”, 32 дугаар зүйлийн 32.1.1 Засаг даргын бүрэн эрхт “Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэ**н** аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

### 1.2. Зорилго

Нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангахад оршино.

### 1.3. Хамрах хүрээ

1.3.1.Энэхүү төлөвлөгөөг Налайх дүүргийн хэмжээнд тохиолдсон гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлнэ.

1.3.2. Дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь Онцгой комисс, шуурхай штаб, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.

1.3.3. Гамшгийн үед Онцгой комисс, Онцгой байдлын байгууллагаас тогтоосон газарт, заасан хугацаанд томилгоот хүч хэрэгслийг бэлэн байлгах, техник, багаж хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах үүргийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн, хууль сахиулах байгууллага хүлээнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ,

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

**2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

Үүнд: Доорх арга хэмжээг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Засаг даргын тамгын газар, Гамшгаас хамгаалах албадууд тухайн жилийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган тайлагнах.

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| **Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл** | | | | |
| 1. | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай зардлыг төсөвт тусгах. | 12 сард | ИТХ | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайлагнах. | I улиралд | ГЭБОНЗ | ОБХ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зөвлөмж боловсруулах, байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх. | I-IV улирал | ОБХ | ГЭБОНЗ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах; | I-IV улирал | ГЭБОНЗ-ийн Ажлын алба | ГЭБОНЗ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаар холбогдох байгууллага, удирдлагуудад чиглэл хүргүүлэх; | XII сард | ГЭБОНЗ | Дүүргийн ЗДТГ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах | I-IV улирал | ГЭБОНЗ | ОБХ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх | I-IV улирал | ГЭБОНЗ | Дүүргийн ЗДТГ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх | I-IV улирал | ГЭБОНЗ | ГЭБОНЗ-ийн гишүүн байгууллагууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх, сурталчлах | I-IV улирал | ГЭБОНЗ | ОБХ |
| **Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай салбар зөвлөл** | | | | |
| 2. | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, | I, IV улирал | Газар зохион байгуулалтын алба ГХБАСЗ | ОБХ |
| | Барилга байгууламжид тэсвэржилтийн үнэлгээг хийлгэх, шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх, | I-IV улирал | Дүүргийн ГХБАСЗ | Дүүргийн ЗДТГ |
| | Сургууль цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийг хүчитгэх арга хэмжээг зохион байгуулах, шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх, | I-IV улирал | Дүүргийн ГХБАСЗ | Дүүргийн ЗДТГ |
| **Дүүргийн Онцгой комисс** | | | | |
| 3. | Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах арга хэмжээг тусгах; | 2024-2028 он | ЗДТГ | ЗДТГ-ын харьяа нэгжүүд |
| | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх; | 3 жил тутам | ЗДТГ | Дүүргийн Онцгой комисс |
| | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас хэрэгжүүлж буй “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; | 3 жил тутам | ЗДТГ | Захирамжаар томилогдсон ажлын хэсэг |
| | Бага дунд төвөгшилтэй барилга байгууламж, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих ажлыг төлөвлөх, зардлыг холбогдох үе шаттай шийдвэрлэх, төсөвт тусгах, хэрэгжүүлэх; | I-IV улирал | Газар зохион байгуулалтын алба | ЗДТГ |
| | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, зарцуулах; | Жилдээ | ИТХ | ЗДТГ |
| | Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах; | I-IV улирал | ОБХ | ЗДТГ |
| | Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр цугларах  талбай, түр байрыг томилгоожуулах, бэлтгэх, газрын баталгаажуулалтад хяналт тавих; | I-IV улирал | ОБХ | ИТХ, Газар зохион байгуулалтын алба |
| | Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах; | I-IV улирал | ОБХ | ЗДТГ |
| | Цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон | I-IV улирал | Газар зохион | ЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх; | | байгууллалтын алба | |
| | Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа гаргах, нөөцийн нөхөн бүрдүүлэлтийг зохион байгуулах; | I-IV улирал | ЗДТГ-ын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс | |
| | Далан, суваг шуудуу, инженерийн байгууламжийн бэлтгэл арга хэмжээг нарийвчлан төлөвлөх, хэрэгжүүлэх; | I-IV улирал | ЗДТГ | Дүүргийн менежер, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс |
| | Түлш, эрчим хүчний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, нөөц эх үүсвэрийг бэлэн байлгах; | I-IV улирал | Түлш эрчим хүчээр хангах алба | ЗДТГ |
| | Холбоо, мэдээллийн хэрэгслийн найдвартай ажиллагааг хангуулах, нөөц эх үүсвэрийг бэлэн байлгах; | I-IV улирал | Мэдээлэл харилцаа холбоо сүлжээ ТӨХК | ЗДТГ |
| | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, 32 дугаар зүйл, 51.2 дахь хэсэгт заасныг тус тус хэрэгжүүлэх. | Жилдээ | ЗДТГ | ОБХ |
| | Гамшгаас хамгаалах албадын чиг үүрэг | | | |
| 4. | Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагуудтай харилцан ажиллах<br>-Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх<br>- Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах<br>-Дархлаажуулалт, ариутгал, халдваргүйтгэл хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр болон түгээх цэгийн үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдал, ус хангамжийн тасралтгүй байдлыг хангах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Хээрийн эмнэлэг дэлгэх тооцоо, судалгаа гаргаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах,<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | | Эрүүл мэндийн алба | |
| | -Цацраг, хими, биологи, тэсрэх дэлбэрэх бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой асуудлыг мөрдөн шалгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах<br>-Гамшгийн үед эргүүл, хяналтыг гарган аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, таслан зогсоох, арга хэмжээг төлөвлөх, бэлэн байдлыг хангуулах<br>-Голомтын бүсэд эргүүл, постуудыг гарган аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах<br>-Эрэн хайх, аврах хүч хэрэгслийг голомтод саадгүй нэвтрүүлэх, хязгаарлалтын дэглэм тогтоох, бэлэн байдлыг хангуулах | | Хэв журам сахиулах алба | |

| | | |
|---|---|---|
| | -Улсын онц чухал объектуудын харуул хамгаалалтыг зохион байгуулах<br>-Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд хүргэх ажилд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Гамшигт нэрвэгдэгсдийн талаарх мэдээлэл цуглуулах, сураггүй алга бологсдыг шалган тогтоох, эрэн сурвалжлах, нас барагчдыг таниулах, нэр хаягийг тогтоох ажлыг зохион байгуулах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | |
| 5. | -Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээ, мэдээлэл, сансрын хиймэл дагуулын үзэгдлийн зураглал гаргах, олон нийт, иргэдэд мэдээлэх<br>-Байгаль, цаг агаарын гаралтай гамшигт болон аюулт үзэгдэл, цацраг, химийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийж урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах<br>-Цацрагийн ослын тухай мэдээг орон нутаг болон холбогдох мэргэжлийн байгууллагаас хүлээн авч, мэдээлэх, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх<br>-Гамшгийн үед химийн хорт болон аюултай бодис алдагдах, аюул учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Цацраг, химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй ослын хор уршгийг арилгах хариу арга хэмжээг удирдлага зохион байгуулахад шаардлагатай багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгслийн нөөц бүрдүүлэх, нэмэгдүүлэх бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг зохион байгуулах<br>-Цацраг, химийн чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад ажилдаг мэргэжлийн ажилтануудын бүртгэл, судалгаа хийх.<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Байгалийн болон цацраг, химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба |
| 6. | -Гамшгийн үед салбарын хэмжээнд тогтвортой байдлыг хангах<br>-Зорилтот бүлгийн иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, гамшгийн үед шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Гамшгийн үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах, жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Эмзэг бүлгийн болон эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгаа гаргах, шаардлагатай бүх талын тусламж үзүүлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдний онцлогт тохирсон гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт олгох<br>-Гамшгийн үед олон нийтэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах, бэлэн байдлыг хангуулах<br>-Нүүлгэн шилжүүлэх байранд ирсэн иргэдэд нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, бэлэн байдлыг хангуулах<br>- Түр хоргодох байр бэлтгэх, иргэдийг байрлуулах, ажлыг зохион байгуулах | Хүн ам, нийгмийн хамгааллын алба |

| | | |
|---|---|---|
| | - Түр хоргодох байранд байрлуулсан иргэдийн аюулгүй байдал, тухайн орчны болзошгүй эрсдэлд хяналтыг хэрэгжүүлнэ<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | |
| 7. | -Гамшгийн үед ашиглагдах шаардлагатай тээврийн хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг хангуулах<br>-Улс, хот хоорондын авто замын чиглэлийг өөрчлөх, хаах, нөөц зам гаргах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нийцүүлж авах<br>-Гамшиг ослын үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх, нөөц зам, гүүрний судалгаа гаргах, нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшгийн голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээг үзүүлэх, бэлэн байдлыг хангах<br>- Гамшгийн голомтод эвдэрч сүйдсэн, нурангид даргадсан, хаагдсан автозамыг засварлах, нээх<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Зам тээврийн алба |
| 8. | -Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр шаардлагатай нөөцийг норм, стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, сэлгэх ажлыг зохион байгуулах, холбогдох аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулах<br>-Хүнсний бүтээгдэхүүний хангалт, тэдгээрийн тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, хяналт тавих<br>-Хүнсний бүтээгдэхүүний тээврийн үйл ажиллагааг хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн удирдлага, зохион байгуулалтаар хангах<br>-Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэдгээрийн нутагшсан сорт, бэлчээрийн ургамлын хортон шавж, биологийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Малчдыг даатгалд хамруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах<br>-Ган, зудын эрсдэлийн үнэлгээг үндэслэн малчид, тариаланчдад урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, зөвлөмж хүргэх<br>-Сумдын гамшгийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих<br>-Бэлчээрийн зохион байгуулалт, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн талаар нэгдсэн мэдээллээр хангах, ган, зудын аюулаас мал сүргийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Бэлчээрийн болон тарималь ургамал, ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих<br>-Аймгийн хэмжээнд ажиллаж буй хүнсний агуулах, зоорийн судалгаа гаргах, гамшгийн үед дайчлан ажиллуулах бэлэн байдлыг хангуулах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Хүнс, хөдөө аж ахуйн алба |

| | | |
|---|---|---|
| 9. | -Хот, тосгон, барилга байгууламж барих, өргөтгөх, зураг төсөлд норм, стандартыг мөрдүүлэх<br>-Аймаг, сумын хэмжээнд барилгын насжилт, барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд үнэлгээ, паспортжуулалт хийх, хүн амд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох, зардлыг шийдвэрлүүлэх<br>-Гамшгийн үед ашиглах барилга байгууламж, зам гүүр, машин механизм, тээврийн хэрэгслийн байршил, хүчин чадлын судалгаа гаргаж тэдгээрийг дайчлан ашиглах боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг тодорхойлох<br>-Гамшгийн голомтод үйл ажиллагаа зохион байгуулах инженерийн хангалтын арга хэмжээг төлөвлөх<br>-Гамшгийн үед шаардлагатай мэдээлэл, хот байгуулалт, барилга байгууламжийн зураг, төслөөр хангах<br>-Бүх төрлийн байр зүйн болон план зургаар хангах, гамшгийн үед ОК-ын даргын ажлын болон шийдвэрийн зургийг боловсруулах бүрэлдэхүүнийг томилох, сургаж дадлагажуулах<br>-Хүчитгэх шаардлагатай барилга, байгууламжийн судалгаа гаргах, хүчитгэл хийх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах, зөвлөмж чиглэл өгөх<br>-Үерийн хамгаалалт, далан сувгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цэвэрлэгээ, үйлчилгээ хийх хуваарийг хийж ЗД-аар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих<br>-Гамшгийн үеийн геодезийн хэмжилтийн ажил гүйцэтгэх багаж, тоног төхөөрөмжөөр хангах<br>-Гамшгийн үед орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах боломжтой барилга байгууламжийн судалгаа, тооцоо гаргах, томилгоожуулж танилцуулах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Барилга, хот байгуулалтын алба |
| 10. | -Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиог төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хүн амд зарлан мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулах бэлэн байдлыг хангах<br>-Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг нөхөн сэргээх, техник хэрэгслийг бэлэн байдлыг хангах, гэмтэл саатлыг арилгах, нөхөн сэргээх, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хэвийн найдвартай ажиллагааны бэлэн байдлыг хангах<br>-Гамшгийн үед харилцаа холбоог бүх төрлийн сувгаар зохион байгуулж, мэдээ мэдээллийг саадгүй дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг хангах мэдээллийн технологийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, оновчтой шийдлийг зохион байгуулах<br>-Гамшгийн үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн систем, сүлжээг хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, судалгааг нэгтгэн бэлэн байдлыг хангуулах<br>-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь дэд бүтэц, түүний нөөц сувагчлал, нөхөн хангалтыг хийж бэлэн байдлыг хангах<br>-Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалтын үед нөхцөл байдлын мэдээлэл бүрдүүлэх зорилгоор мэдээллийн системийг хөгжүүлэх, холбох, мэдээллийн санг бүрдүүлэх, нөөцлөх | Мэдээлэл, харилцаа холбооны алба |

| | | |
|---|---|---|
| | - Гамшгийн голомтод тандалт хийх, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн судалгаа гаргах, бэлэн байдлыг хангуулах<br>- Гамшгийн голомтод ажиллах ГХА, МА харилцан ажиллагаа, холбоо зохион байгуулалтыг хангах, радио холбооны бэлэн байдлыг хангах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | |
| 11. | -Гамшгийн үед онц чухал объектуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах<br>-Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийг техникийн үүдэлтэй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Эрчим хүчний зохицуулалт, цахилгаан эрчим хүчний хангалтад хяналт тавих, хязгаарлах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх<br>-Нөөц цахилгааны эх үүсвэрийн судалгааг гаргах, шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах<br>Гамшгийн үед эрчим хүч, дулааны тасалдал, гэмтлийг шуурхай арилгах бүлгүүдийн бэлэн байдлыг хангуулах шаардлагатай сэлбэг, материал хэрэгсэлийн нөөц бүрдүүлэх<br>Гамшгийн үед эрчим хүч, дулаанаар хангах ажиллагаанд шаардагдах дайчлан гаргах хүч хэрэгсэлийн судалгааг гаргах,<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Түлш, эрчим хүчээр хангах алба |
| 12. | -Шатахуун түгээх станцуудад гамшгийн нөөцийг бүрдүүлэх, тооцоо судалгааг гаргах, хяналт тавих<br>-Гамшгийн үед ашиглах шаардлагатай хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, бэлэн байдлыг хангуулах<br>-Уурхайн уулын үйлдвэрийн ослын голомтод ажиллах бүлгүүдийн бэлэн байдлыг хангуулах<br>-Гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглах нүүрсээр хангах арга хэмжээг зохион байгуулах, нөөцийг бүрдүүлэх<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Эрдэс баялаг, уул уурхайн алба |
| 13. | -Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, дархлаажуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх<br>-Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх<br>-Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, голомтод хорио цээр, эрүүл ахуйн дэглэмийг хэрэгжүүлэх, шаардагдах нөөцийг бүрдүүлэх, ДМАЭМБ-ын дүрмийн дагуу мэдээлэх<br>-Мал, амьтны гоц халдварт өвчний үед манлайлж ажиллах, сумдыг удирдлага зохион байгуулалтаар хангах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Мал эмнэлгийн алба |

| | | |
|---|---|---|
| 14. | -Гамшгийн үед бүх шатны боловсролын байгууллагын дотуур байранд амьдарч буй суралцагчдын эрүүл мэнд, хоол хүнс, аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудалд анхаарах, цахим сургалт, мэдээллийг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах<br>-Гамшгийн үед боловсролын байгууллагын барилга байгууламжийг түр орон байраар ашиглах боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах<br>- Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Боловсролын алба |
| 15. | - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг, 51.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх;<br>- Байгууллагын аюулгүй байдлыг тогтмол шалгах, энэ чиглэлээр холбогдох албан тушаалтны томилох;<br>- Байгууллагын гал түймэр, гамшгийн аюулгүй байдлыг хангах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагатй хамтран ажиллах;<br>- Гамшгийн үед байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;<br>- Тусгай зорилалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах сургаж дадлагажуулах, холбогдох байгууллагатай мэдээ мэдэлэл солилцох.<br>-Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Бусад хуулийн этгээд |
| | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Аврах, сэргээн босгоход шаардлагатай төсөв, зардлыг тооцоолох<br>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй аврагчид, ажилтан алба хаагч болон иргэдэд хоол хүнс, ундны ус, дулаан хувцас, түр орон байраар хангах<br>- Хэрэгцээ шаардлагыг түргэн тодорхойлж хангалт хийх Аймгийн ОК-ыг мэдээ, мэдээллээр хангах<br>-Бусад урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах | Санхүү нөөц хангалтын алба |

## 2.3. Гамшгаас хамгаалах сургалт:

2.3.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан сургалтыг тухайн шатны Засаг дарга, Онцгой байдлын хэлтэс, Олон Улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.

| д/д | Зохион байгуулах сургалт, арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1. | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах (Засаг даргын баталсан хуваарийн дагуу) зохион байгуулах | жилд 1 удаа | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс | ДОК |
| 2. | Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг зохион байгуулах | Жилд 2-оос доошгүй удаа | Дүүргийн Засаг дарга | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс Улаан загалмайн хороо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд суралцагчдын насны онцлогт тохирсон сургалтыг үе шаттай зохион байгуулж, гамшгаас хамгаалах мэдлэг дадал эзэмжүүлэх. | Жилд 1 удаа | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Дүүргийн Боловсролын хэлтэс |
| 4. | Хуулийн этгээд ажилтан, алба хаагч нарын гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулах | Жилд 1 удаа | Тухайн ААНБ | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс |

2.2.2. Иргэн, хуулийн этгээдэд зохион байгуулсан гамшгаас хамгаалах сургалтын дүн мэдээг улирал бүр гамшгийн асуудал эрхэлсэн албан тушаалтан нэгтгэж, Онцгой байдлын хэлтэст хүргүүлэх, дүүргийн Онцгой комиссын даргад танилцуулна.

## Гурав. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

3.1. Энэ төлөвлөгөөг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны аж ахуйн нэгж байгууллагууд бэлэн байдлыг хангах дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ:

| № | Бэлэн байдлыг хангах арга хэмжээ | Хугацаа | Удирдлага зохион байгуулалт | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| 1. | Гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах томилгоот хүч хэрэгсэл (хүн, техник, багаж, тоног төхөөрөмж, зэвсэглэмж, хамгаалах хэрэгсэл)-ийн судалгааг гаргах, тодотгох, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, тэдгээрийг дайчлан ашиглах боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах; | Жилд 2 удаа | ДОК-ын ШШ | Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги |
| 2. | Гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах, дохиогоор түргэн цугларах дадлага сургууль зохион байгуулах; | Жилд 1 удаа | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Монголын Мэдээлэл холбоо ХХК, Монголын Цахилгаан холбоо ХХК |
| 3. | Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах мэдээ мэдээлэл солилцох боломж бүрдүүлсэн байх; | Жил бүр | ДОК-ын дарга | Монголын Мэдээлэл холбоо ХХК, Монголын Цахилгаан холбоо ХХК |
| 4. | Гамшгийн үед байгууллагад ашиглагдах бүх төрлийн нөөц (хүнс, шатах тослох материал, бараа материал, бусад) бүрдүүлэх, нэмэгдүүлэх; | Жил бүр | ДОК | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| 5. | Ажилтан, алба хаагч нарыг гамшгийн үед ажиллах шуурхай штаб, мэргэжлийн анги, бүлэг, хэсэгүүдэд томилгоожуулж, сургаж дадлагажуулах; | Жилд 1 удаа | ДОК-ын дарга | Дүүргийн Онцгой байдлын хэлтэс |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6. | Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, сургаж дадлагажуулах | Жилд 2 удаа | ДОК, Дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги |
| 7. | Дүүргийн Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжилтийг ханган ажиллах. | Жил бүр | ДОК | Гамшгаас хамгаалах орон нутгийн алба |
| 8. | Удирдах бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах талаарх хууль эрх зүйн мэдлэг болон гамшгийн үед шийдвэр гаргах чадвар эзэмших; | Жил бүр | ДОК | Дүүргийн Онцгой байдлын газар |
| 9. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын хангах, үзлэг явуулах, үнэлэх журам” А/383 дугаар тушаалын хэрэгжилт, биелэлтийг хангуулах, үнэлж дүгнэх; (Бэлэн байдлыг Онцгой байдлын байгууллагаас үнэлж дүгнэнэ) | Тухай бүр | Аймгийн Онцгой байдлын газар | Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги |
| 10. | - Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших;<br>- Аюулгүйн талбай, түр цугларах цэг, түр амьдрах байрныхаа талаар мэдлэг эзэмших;<br>- Мэргэжлийн ангид томилогдсон бүрэлдэхүүн гамшгийн үед холбогдох хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадвар эзэмших;<br>- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | Жил бүр | Ажилтан, алба хаагчид | |

Гуравдугаар бүлэг. Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт

**3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ (Дүүргийн Онцгой комисс, мэргэжлийн анги, хуулийн этгээд, иргэн):**

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хэрэгжүүлэх;
- Дүүргийн онцгой комиссын Шуурхай штабыг хоблогдох журмын дагуу байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах;
- Улсын болон нийслэлийн Онцгой комиссоос гаргасан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх;
- Гамшиг ослын үед Шуурхай штабыг байгуулж, гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, шуурхай бүлгийн бэлэн байдлыг хангах;
- Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр нь танилцуулах;
- Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Дээд шатнаас гарсан шийдвэрийг иргэдэд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- Улсын болон орон нутгийн нөөц болон хүмүүнлэгийн тусламж хүсэх, холбогдох тооцоо, судалгаа гаргаж, нийслэлийн Онцгой комисст хүргүүлж, хуваарилсан нөөцийг үр дүнтэй зарцуулж, хяналт тавьж, тайлагнах;
- Иргэн, хуулийн этгээдийг дайчлан гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Дэд бүтцийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангах, аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;

3.2. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүтэц



3.3 Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт

3.3.1. Гамшиг ослын нөхцөл байдал үүссэн үед нөхцөл байдлаас шалтгаалан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах Шуурхай штабыг дүүргийн Онцгой комиссын даргын шийдвэрээр байгуулна.

3.3.2. Налайх дүүргийн Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг “Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний үндэсний төв” ТББ-ын шинжээчдийн баг 2024 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэсэн бөгөөд уг үнэлгээний үр дүнг үндэслэн энэхүү төлөвлөгөөг боловсруулав. Үнэлгээгээр газар хөдлөлт, объектын гал түймэр, хүчтэй салхи шуурга, ган, зуд “Их” түвшинд, мал, амьтны гоц халдварт өвчин, хүний халдварт өвчин “Дунд” түвшинд тодорхойлогдсон тул гамшгийн үед удирдлагаар хангах, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг дараах байдлаар тогтоов./тухайн дүүрэг гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн бол тэр тухай мэдээллээ оруулах/

3.3.5.Гамшгийн нөхцөл байдлыг үнэлж дүүргийн Онцгой комиссын дарга Монгол Улсын шадар сайдын 2025 оны 05 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ын дагуу шуурхай штабыг байгуулах шийдвэр гаргана. Шуурхай штаб дараах бүтэцтэй байна.

3.3.6. Гамшгийн үед удирдлагаар хангах, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллага:

| д/д | Аюулт үзэгдэл, ослын төрөл | Удирдан зохицуулах | Зохион байгуулж хэрэгжүүлэх | Дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах алба, байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Газар хөдлөлт | ДОК, ОБХ | ДОК-ын ШШ | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, ТЦбХСБ, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээд |
| 2 | Хүний гоц халдварт өвчин | | Эрүүл мэндийн алба | Эрүүл мэндийн алба, Хэв журам сахиулах алба, |
| 3 | Ган | | Хүнс, хөдөө аж ахуйн алба | Хэв журам сахиулах алба, Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, |
| 4 | Зуд | | Хүнс, хөдөө аж ахуйн алба | Хэв журам сахиулах алба, Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба, Эрүүл мэндийн алба, Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, |
| 5 | Хүчтэй цасан болон шороон шуурга | | ДОК-ын ШШ | Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, Эрүүл мэндийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн алба, Хэв журам сахулах алба, Эрчим хүч, дулаанаар хангах алба, Цахилгаан эрчим хүчээр хангах алба |
| 6 | Үер | | Газарзүйн мэдээллийн сан зургаар хангах алба | Газарзүйн мэдээллийн сан зургаар хангах алба, Эрүүл мэндийн алба, Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, Хэв журам сахиулах алба, |
| 7 | Мал амьтны гоц халдварт өвчин | | Мал эмнэлгийн алба | Хэв журам сахиулах алба, Байгалийн болон цацраг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, |
| 8 | Ой, хээрийн түймэр | | ДОК-ын ШШ | ТЦбХСБ, Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, Хэв журам сахиулах алба, Ойн санг гэрээгээр эзэмшигч ААНБ |
| 9 | Цацраг идэвхт, химийн хорт болон аюултай бодис алдагдах | | Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба | ТЦбХСБ, Эрүүл мэндийн алба, Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба, Хэв журам сахиулах алба |




Шуурхай штабын бүрэлдэхүүн, бүлэг хэсгийг гамшгийн нөхцөл байдал, цар хүрээнээс хамаарч нэмж хасаж болно.

Дөрөв. Гамшгийн мэдээлэл дамжуулах

4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллага болон иргэдэд дамжуулах:

4.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын болон нөхцөл байдлын мэдээллийг дүүргийн Онцгой байдлын хэлтэс, чиглэл хариуцсан гамшгаас хамгаалах алба болон дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабт тухай бүр шуурхай дамжуулна.

4.1.2. Үүрэн холбооны сүлжээ тасарсан, мэдээлэл дамжуулах үндсэн суваг ажиллагаагүй болсон тохиолдолд сансрын холбоо, радио холбоо (богино болон хэт богино долгионы станц), сүлжээ үүсгэгч төхөөрөмжийг ашиглана. Байгууллага, алба мэргэжлийн ангиуд сансрын холбоо болон нөөц холбооны хэрэгслийн бэлэн байдлыг урьдчилан хангасан байна.

4.1.3. Техникийн бүх төрлийн холбоо ашиглах боломжгүй болсон нөхцөлд мэдээллийг биетээр хүргэх "Биет холбоочин"-ыг томилгоожуулна. Биет холбоочны

ажиллах маршрут, унах унаа, холбоо барих журмыг жил бүрийн 6 дугаар сард багтаан тодотгоно.

4.1.4. Дүүргийн хэмжээнд зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч, холбоо барих утасны жагсаалт, биет холбоочныг жилд 1-ээс доошгүй удаа болон албан тушаалтан өөрчлөгдөх бүрд тодотгол хийнэ.

Дүүргийн хэмжээнд мэдээ мэдээлэл дамжуулах

Дүүрэгт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын мэдээллийг Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Онцгой комиссын даргад мэдээлнэ.

Дүүргийн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсч болзошгүй гамшгийн үед тухайн шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын шийдвэрээр зарлан мэдээллийн хэрэгслээр дамжуулна. /МУ-ын ЗГ-ын 339 тогтоолын 4.3.1/

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг дамжуулах бүдүүвч




Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:

4.2.1. Гамшгийн зарлан мэдээллийг дараах бүдүүвчийн дагуу дамжуулна:

4.2.1.1. Газар хөдлөлтийн аюулын тухай анхааруулах бүдүүвч:



4.2.1.2. Бүх төрлийн Гамшгийн үеийн анхааруулах бүдүүвч:



Тав. Гамшгийн хариу арга хэмжээ

**5.1. Гамшгийн нийтлэг хариу арга хэмжээ, түүний удирдлага зохицуулалт:**

Тактикийн түвшинд:

5.1.1. Улсын болон нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх;

5.1.2. Шуурхай штабыг байгуулж, гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, шуурхай бүлгийн бэлэн байдлыг хангах;

5.1.3. Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр нь танилцуулах;

5.1.4. Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах;

5.1.5. Дээд шатнаас гарсан шийдвэрийг малчин иргэдэд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах;

5.1.6. Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж, аюулгүй байдлыг хангуулж ажиллах;

5.1.7. Улсын болон орон нутгийн нөөц болон хүмүүнлэгийн тусламж хүсэх, холбогдох тооцоо, судалгаа гаргаж, аймгийн Онцгой комисст хүргүүлж, хуваарилсан нөөцийг үр дүнтэй зарцуулж, хяналт тавин тайлагнах;

5.1.8. Иргэн, хуулийн этгээдийг дайчлан гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.1.9. Дэд бүтцийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангах, аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;

5.2 Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээ

5.2.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед мэдээ, мэдээллийг Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 92 дугаар тушаалаар батлагдсан “Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам”–ын хавсралтад заасан бүдүүвчийн дагуу дамжуулна.

5.2.2 Газар хөдлөлтийн үеийн хариу арга хэмжээ

Газар хөдлөлтийн гамшгийн аюул (Налайх дүүрэг)

Нийт нутаг дэвсгэрийн 136.3 км2 нь Маш их түвшинд байна. Аюулт дараах дэд бүтэц болон барилга байгууламж өртөх эрсдэлтэй байна.

Эрчим хүчний байгууламж-1,

Боловсролын байгууламж-10,

Эрчим хүчний шугам-11.49 км





## 5.2.3 Газар хөдлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөө

| д/д | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах нэгж | Хүч хэрэгсэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүн | Техник хэрэгсэл |
| 1 | Зарлан мэдээлэл хүргэх. | Серень дохиог ажиллуулах | Ц+00:05 | МХХА | Хүч хэрэгслийг оруулна | |
| 2 | | Биет холбоочноор мэдээ хүргүүлэх | Ц+01:00 | МХХА | | |
| 3 | Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад мэдээлэх. | Газар хөдлөлт болсон тухай мэдээлэл өгөх | Ц+00:10 | ОБХ | | |
| 4 | Дүүргийн Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг цуглуулах. | ДОК-ын бүрэлдэхүүнийг бүртгэх | Ц+00:30 | ГХА, МА-ийн дарга нар | | |
| | Тандалтын бүлэг гаргах | ДОК-оос томилгоожуулах | Ц+00:50 | | | |
| 5 | Онцгой комиссын гишүүдэд мэдээлэл дамжуулах. | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлэх. | Ц+00:30-аас | ОБХ | | |
| 6 | Шуурхай үнэлгээ хийх. | Харилцаа холбоо тасраагүй тохиолдолд иргэдээс дуудлага мэдээллийг хүлээн авах. | Ц+00:30-аас | ДОК | | |
| 7 | | Биетээр тандалт хийж мэдээлэл цуглуулах. | Ц+00:30-аас | ДОК | | |
| 8 | | Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр агаараас нөхцөл байдлыг тандах. | Ц+00:20-аас | ДОК | | |
| 9 | Дүүргийн Онцгой комиссыг яаралтай хуралдуулах. | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхижүүлэх. | Ц+00:30-аас | ДОК | | |
| 10 | | Шуурхай штабыг байгуулан 24 цагийн жижүүрийн хуваарь гаргах, томилгоо хийх. | Ц+01:00-аас | ДОК | | |
| 11 | | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг идэвхжүүлэх, хүч хэрэгслийг хуваарилах. | Ц+01:00-аас | ДОК, ОБХ | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Иргэдийг үүссэн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах. | Бүх нийтийн харилцаа холбоо, олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдээ, мэдээллийг түгээх. | Ц+01:00-аас | Сурталчилгааны алба | | |
| 13 | Эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах. | Нурсан барилгаас нэрвэгдэгсдийг гаргах эрэн хайх, аврах үйл ажиллагааг зохион байгуулах. | Ц+00:10-аас | ОБХ, ГХА,МА | | |
| 14 | Гал түймэр унтраах, тархалтыг зогсоох | Газар хөдлөлтөөс үүдэлтэй объектын гал түймрийг унтраах, дэлбэрэлтээс сэргийлэх. | Ц+00:40-аас | ОБХ | | |
| 15 | | Голомтын бүсэд хамгаалалт тогтоох, нийтийн аюулгүй байдлыг хангах. | Ц+00:05-аас | ХЖСА | | |
| 16 | Хэв журам сахиулах | Төв болон туслах замуудыг чөлөөлж, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах. | Ц+24:00-аас | ЦХ, ЗТА | | |
| 17 | | Улсын онц чухал объектуудыг хамгаалалтад авах, хяналтыг сайжруулах. | Ц+01:00-аас | ХЖСА дотоодын цэрэг | | |
| 18 | Нэрвэгдэгсдэд туслах, эмнэлгийн яаралтай тусламж | Аюулгүй талбайд иргэдийг бүртгэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлж, ангилах. | Ц+00:15-аас | ЭМА, МУЗН | | |
| 19 | | Цахилгаан | Ц+01:30-аас | ТЭХА | | |
| 20 | Дэд бүтцийг сэргээх | Дулаан, цэвэр бохирын шугам | Ц+06:00-аас | ТЭХА | | |
| 21 | | Харилцаа холбоо | Ц+12:00-аас | МХХА | | |
| 22 | Зам, гүүрний саадыг арилгах | Төв болон туслах замын нурангийг цэвэрлэх, шаардлагатай тохиолдолд түр зам гаргах. | Ц+03:00-аас | ЗТА, Хотын стандарт, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс | | |
| 23 | Хээрийн эмнэлэг дэлгэх | Нэрвэгдсэн иргэдийг хээрийн эмнэлэг рүү зөөвөрлөх. | Тухай бүр | ЭМА, МУЗН | | |
| 24 | | Бэртэж гэмтсэн иргэдийг анхны тусламж үзүүлж эрэмбэлэх. | Тухай бүр | ЭМА, МУЗН | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | | Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээ өгөх | Ц+12:00-аас | ЭМА, МУЗН | | |
| 26 | Алба, мэргэжлийн ангийн хангамж | Үүрэг гүйцэтгэж буй хүн хүч, техник хэрэгслийн зардлын тооцоог гаргах, шийдвэрлэх. | Ц+24:00-дуустал | ДОК-ын дарга | | |
| 28 | Хорогдох байраар хангах | Гэр оронгүй болсон иргэдийг түр орон байранд хүлээн авах бүртгэх, эрэмбэлэх. | Ц+12:00-аас | ХНХА | | |
| 29 | Нүүлгэн шилжүүлэх | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | Ц+02:00-аас | ДОК, ГХА, МА | | |
| 30 | Нийгмийн халамж, хамгаалал | Тусгай хэрэгцээт иргэдийг бүртгэж, тусламж үзүүлэх. | Ц+06:00-аас | ХНХА | | |
| 31 | Тандалтын бүлэг ажиллуулах | Нурах магадлалтай барилга байгууламжийн судалгааг гаргах. | Ц+12:00-аас | ГХБХБА | | |
| 32 | | Цацраг химийн болон тэсэрч дэлбэрэх бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх. | Ц+12:00-аас | ЦАҮМА | | |
| 33 | | Бүх төрлийн халдварт өвчин үүсэх болон тархахаас урьдчилан сэргийлэх. | Ц+12:00-аас | ЭМА | | |
| 34 | Нөхцөл байдлыг дахин үнэлэх | Биетээр тандалт хийж мэдээлэл цуглуулах. | Ц+00:30-аас | ДОК, ГХА, МА | | |
| 35 | Ар тал хангалт | Хоол, хүнсний хангалт | Ц+02:00-аас | ХХААА | | |
| 36 | | Шатахууны хангалт | Тухай бүр | ТЭХА | | |
| 37 | | Хувцас хэрэгслийн хангалт | Тухай бүр | ХНХА | | |
| 38 | | Шаардлагатай техник хэрэгслийн хангалт | Тухай бүр | ЗТА | | |
| 39 | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт | Тухай бүр | ЭМА | | |
| 40 | Хүмүүнлэгийн тусламж зохицуулалт | Хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хуваарилах. | Ц+24:00-аас | ЗДТГ-ын ажлын хэсэг | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 41 | Нас барагсдыг таниулах | Буцалтгүй нэрвэгдэгсдийг бүртгэх, судалгаа гаргах. | Ц+72:00-аас | ЭМА | | |
| 42 | | Буцалтгүй нэрвэгдэгсдийг зөөвөрлөх ажлыг зохион байгуулах, хадгалах байрыг бэлтгэх. | Ц+72:00-аас | Цагдаагийн хэлтэс | | |
| 43 | | Буцалтгүй нэрвэгдэгсдийг таниулах, ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгөх. | Ц+72:00-аас | Цагдаагийн хэлтэс | | |
| 44 | Ариутгал халдваргүйжүүлэлт зохион байгуулах | Дүүргийн хэмжээнд бохирдол үүссэн газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийх. | Тухай бүр | ДОК | | |

**5.3 Үерийн хариу арга хэмжээ** /Эрсдэлийн үнэлгээгээр эрсдэл өндөр гарсан аюулт үзэгдлийн төрлүүдээр хариу арга хэмжээг төлөвлөх/

5.3.1. Налайх дүүрэг нь үерийн эрсдэлийн аюулын түвшин тухайн аймгийн нутаг дэвсгэрийн 23.994.9 км2 талбай нь **Маш бага** түвшинд, 49.217 км2 нь **Бага** түвшинд, 1477.8 км2 нь түвшинд байна.





5.3.2 Хариу арга хэмжээний төлөвлөгөө

| д/д | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах нэгж | Хүч хэрэгсэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүн | Техник хэрэгсэл |
| 1 | Зарлан мэдээллийг хүргэх | Үерийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх | Ц+00:05 | АОК-ын дарга, Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсэг | Хүний тоог оруулах | Техник хэрэгслийн тоог оруулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Үерийн гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Ц+00:20 | Барилга, хот байгуулалтын алба Код-4 | | |
| 3 | Үерийн гамшгийн тухай дуудлагын талаар шаардлагатай бүх төрлийн мэдээлэл цуглуулах, нэгтгэх | Үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлыг үнэлэх | Ц+00:20 | | | |
| 4 | Шуурхай хуралдааныг зохион байгуулах | Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсгийг хуралдуулах | Ц+01:00 | Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсэг | | |
| 5 | Шуурхай штабыг байгуулах | Голомтын бүсэд шуурхай штабыг байгуулан хариу арга хэмжээ авах | Ц+02:00 | | | |
| 6 | Хүч хэрэгслийг тодотгох | Байгууллагын хүч хэрэгслийг тодотгон төвлөрүүлэх | Ц+02:00 | Барилга, хот байгуулалтын алба | | |
| 7 | Үүссэн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах | Бүх нийтийн харилцаа холбоо, олон нийтийн сүлжээгээр мэдээллийг дамжуулах | Тухай бүр | Сургалт, сурталчилгааны алба | | |
| 8 | Өртөж болзошгүй болон өртсөн хүн, мал, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх | Үерт өртөж болзошгүй, үерт өрсөн газар орноос нүүлгэн шилжүүлэх хүн, мал, амьтан, эд хөрөнгийн судалгаа, нүүлгэн шилжүүлэх дараалал гаргах | Тухай бүр | ГХА, МА | | |
| 9 | Нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх | Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангаан хариу арга хэмжээг хэрэгжүүлэх | Тухай бүр | | | |
| 10 | Хэв журам сахиулах | Голомтын бүсэд хамгаалалт тогтоох, хэв журам сахиулах | Тухай бүр | ГХА, МА | | |
| ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| 1 | Өртсөн нэн шаардлагатай дэд бүтцүүдийг сэргээх, засварлах, хэвийн ажиллагааг хангах | Үерт өртсөн дэд бүтцийн судалгаа, сэргээхэд шаардагдах зардал, хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, засварлах хуваарь гаргах | Тухай бүр | ОБХ, ГХА, МА | Хүний тоог оруулах | Техник хэрэгслийн тоог оруулах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Эвдэрч гэмтсэн дэд бүтцийг засварлах ажиллагааг эхлүүлэх | | | | |
| 3 | Үерийн гамшигт өртсөн мал, амьтныг устгах | Үерт өртсөн мал, амьтныг цуглуулж тогтоосон цэгт булж, халдваргүйжүүлэлт хийж устгах ажлыг зохион байгуулах | 10 хоног | ДОК, ХХААА | | |
| 4 | Ариутгал халдваргүйтгэл хийх | Үерт өртсөн бохирдсон талбайд ариутгал халдваргүйтгэл хийх | | | | |

## 5.4 Объектын гал түймрийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Хариуцах нэгж | Хүч хэрэгсэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дуудлага өгөх | Дүүргийн ОБХ-ын ГТУА-д нэн даруй мэдэгдэх (ирэх хугацааг тооцох) | Ц+00:01 | ОБХ | **Хүч хэрэгслийг оруулах** |
| 2 | Эрчим хүч, таслах | Түймэр гарсан объектын болон зэргэлдээх барилгын цахилгааныг хязгаарлах | Ц+00:05 | Эрчим хүчний алба | |
| 3 | Гал унтраахад дэмжлэг үзүүлэх | Дүүргийн мэргэжлийн анги бэлэн байгаа багаж (гал унтраагуур, элс, ус)-аар түймрийг тархаахгүй тогтоох | Ц+00:05 | ГХА, МА, Сайн дурын хэсэг | |
| 4 | Усны нөөц бүрдүүлэх | Дүүргийн ус зөөврийн машин болон усны худгийг бэлэн болгож, ус дамжуулах шугам, мотор насос угсрах | Ц+00:10 | Чандмань налайх ААТҮГ | |
| 5 | Хөрш объектын хамгаалалт | Түймэр зэргэлдээх барилга руу орохоос сэргийлж хана, дээврийг услах, шатамхай зүйлийг зайлуулах | Ц+00:15 | ОБХ, ГХА, МА, Сайн дурынхан | |
| 6 | Эрэн хайх, аврах | Барилга дотор байгаа хүмүүсийг гаргах, эд хөрөнгийг зөөвөрлөх | Ц+00:10 | ОБХ, ГХА, МА, Сайн дурынхан | |
| 7 | Хэв журам сахиулах | Галын голомт руу иргэдийг ойртуулахгүй байх, ГТУА-д зам чөлөөлөх | Ц+00:05 | Хэв журам сахиулах алба | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Эмнэлгийн тусламж | Түлэгдсэн, утаанд хордсон иргэдэд тусламж үзүүлж, эмнэлэгт хүргэх | Тухай бүр | Эрүүл мэндийн алба | |
| 9 | ГТУА-г угтаж авах | Дүүргээс ирж буй гал унтраах автомашиныг дүүргийн орох цэг дээр угтаж, хамгийн дөт замаар голомт руу хөтлөх | Ц+00:30 (Ойролцоогоор) | Тухайн аж ахуйн нэгж байгууллагын удирдлага | |

## Зургаа. Хангалт зохион байгуулалт

6.1.Гамшгийн үед байгууллагын удирдлагын шийдвэрээр материал хэрэгслийн хангалтыг зохион байгуулна. Гамшгийн үеийн хангалтыг дараах байгууллагууд хэрэгжүүлнэ:

| № | Хангалтын төрөл | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|
| 1 | Харилцаа холбооны техник хэрэгсэл | ДОК | Мэдээлэл харилцаа холбооны алба |
| 2 | Газар зүйн мэдээлэл, байр зүйн зураг хангах | Газар зохион байгуулалтын алба | Байгаль орчны хяналтын улсын байцаагч |
| 3 | Хүн эмнэлэг, эм хэрэгсэл, анхны тусламж | ДОК | Эрүүл мэндийн алба |
| 4 | Орон байр, дулаан хувцас, ариун цэвэр | ДОК-ын нүүлгэн шилжүүлэх бүлэг | Боловсролын хэлтэс |
| 5 | Хоол, хүнс, цэвэр ус | ДОК-ын Хүнсээр хангах алба | Гэрээт байгууллагууд |
| 6 | Ариутгал, халдваргүйтгэл | Дүүргийн Мал эмнэлгийн тасаг | Эрүүл мэндийн, ЗООНОЗ өвчин судлалын төв |
| 7 | Тээврийн хэрэгсэл | ДОК | Зам тээврийн алба |
| 8 | Техник тоног төхөөрөмж, тусгай хувцас | Гамшгаас хамгаалах алба | Мэргэжлийн анги |
| 9 | Хүний нөөц (Хүн хүч) | ЗДТГ, Сайн дурын хэсэг | Төрийн байгууллагууд, Иргэд |
| 11 | Түлш, эрчим хүч | Эрчим хүчний алба | Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны Налайх салбар |
| 12 | Ус, дулаан | Эрчим хүчний алба | Налайх дулааны станц |
| 13 | Шатах, тослох материал (ШТМ) | Эрчим хүчний алба | Мэргэжлийн анги |
| 14 | Мал эмнэлэг, эм бэлдмэл, вакцин | ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасаг | Мал эмнэлгийн тасаг |
| 15 | Өвс, тэжээлийн нөөц | ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасаг | Мал эмнэлгийн тасаг |

Долоо. Нүүлгэн шилжүүлэлт

Найм. Хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг

8.1. Хүмүүнлэгийн тусламжийн удирдлага зохицуулалт

8.1.1. Сумын түвшний хүмүүнлэгийн тусламжийг Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулна.

8.1.2. Гамшгийн хохирол сумын нөөц, боломжоос давсан тохиолдолд Аймгийн онцгой комисс (АОК)-т хүсэлт гаргаж, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах шийдвэр гаргана.

8.1.3. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилахдаа "Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ"-нд суурилж, хамгийн их өртсөн зорилтот бүлэгт илүү хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

8.2 Дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ

| д/д | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| | Нэг. Хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээн авах, бүртгэх | | | |
| 1.1 | Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх | Тухай бүр | ДОК-ын дарга | ДОК-ын ажлын хэсэг |
| 1.2 | Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээнд суурилан нэн шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох | Тухай бүр | ДОК | ДОК-ын ажлын хэсэг |
| 1.3 | Дүүргийн онцгой комиссыг хуралдуулж, хүмүүнлэгийн тусламж авах шийдвэр гаргах | Тухай бүр | ДОК-ын дарга | ДОК |
| 1.4 | Нийслэлийн Онцгой комисст хүмүүнлэгийн тусламж авах талаар хүсэлт гаргах | Тухай бүр | ДОК-ын дарга | ДОК |
| 1.5 | Тодорхой байгууллага, иргэнээс нэр зааж ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авч, бүртгэх, хадгалах | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | ДОК-ын ажлын хэсэг |
| 1.6 | Хүмүүнлэгийн тусламжийн бараа материал техник хэрэгслийг чанар стандартын шаардлагад нийцсэн агуулах болон талбайг бэлтгэн, хадгалах | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | Дүүргийн Засаг дарга нар |
| | Хоёр. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, зарцуулах, хүргэх, олгох | | | |
| 2.1 | Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах | Тухай бүр | ДОК | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| 2.2 | Хүмүүнлэгийн тусламжийг хүргэх тээвэрлэх, машин техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Тухай бүр | ГХА, МА | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3 | Хуваарилсан хүмүүнлэгийн тусламжийг зорилтот бүлэг, нэн шаардлагатай байрлалд хүргэх, хүлээлгэн өгөх | Тухай бүр | ДОК-ын ажлын хэсэг | |
| Гурав. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах үйл ажиллагааны зардал, тайлагналт | | | | |
| 3.1 | Хүмүүнлэгийн тусламжийг хэрэгжүүлсэн талаарх санхүүгийн тооцоог гаргаж, тайлагнах | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | СОК-ын ажлын хэсэг |
| 3.2 | Хүмүүнлэгийн тусламжийг зориулалтын бусаар зарцуулахаас сэргийлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна. | Тухай бүр | Орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтан | СОК-ын ажлын хэсэг<br>Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн |

## 8.3 Тодорхой байгууллага, иргэнээс нэр зааж ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ

| д/д | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| Нэг. Хүмүүнлэгийн тусламж хүлээн авах, бүртгэх, хадгалах | | | | |
| 1.1 | Хүмүүнлэгийн тусламжийн бараа материал техник хэрэгслийг чанар стандартын шаардлагад нийцсэн агуулах болон талбайг бэлтгэн | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | Багийн Засаг дарга нар |
| 1.2 | Тодорхой байгууллага, иргэнээс нэр зааж ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авч, бүртгэх, хадгалах | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | СОК-ын ажлын хэсэг |
| Хоёр. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, зарцуулах, хүргэх, олгох | | | | |
| 2.1 | Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах | Тухай бүр | СОК | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн |
| 2.2 | Хүмүүнлэгийн тусламжийг хүргэх тээвэрлэх, машин техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах | Тухай бүр | Мэргэжлийн анги | |
| 2.3 | Хуваарилсан хүмүүнлэгийн тусламжийг зорилтот бүлэг, нэн шаардлагатай байрлалд хүргэх, хүлээлгэн өгөх | Тухай бүр | СОК-ын ажлын хэсэг | |
| Гурав. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах үйл ажиллагааны зардал, тайлагналт | | | | |
| 3.1 | Хүмүүнлэгийн тусламжийг хэрэгжүүлсэн талаарх санхүүгийн тооцоог гаргаж, тайлагнах | Тухай бүр | Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн | СОК-ын ажлын хэсэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2 | Хүмүүнлэгийн тусламжийг зориулалтын бусаар зарцуулахаас сэргийлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна. | Тухай бүр | Орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтан | СОК-ын ажлын хэсэг<br>Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн |

Ес. Төсөв, санхүү

9.1. Налайх дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, сургалт, дадлага сургууль зохион байгуулах, орон нутгийн нөөц бүрдүүлэх зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.4-т заасны дагуу дүүргийн төсөвт тусгаж, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар (ИТХ) батлуулан хэрэгжилтийг хангана.

9.2. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан ажилласан үйл ажиллагааны зардал, иргэн болон хуулийн этгээдийн техник, тоног төхөөрөмж, байр талбай ашигласны нөхөн олговрыг дүүргийн Онцгой комиссын Шуурхай штаб нэгтгэн тооцож, Засгийн газраас баталсан “Хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаанд дайчлагдсан иргэн, хуулийн этгээдэд нөхөн олговор олгох журам”-ын дагуу шийдвэрлүүлнэ.

9.3. Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийг гамшгийн хор уршгийг арилгах, хариу арга хэмжээ авах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд тэргүүн ээлжинд зарцуулна.

Ес. Бусад

9.1. Энэхүү Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед хэрэгжүүлж, үйл ажиллагааны тайлан мэдээг тухай бүр Нийслэлийн Онцгой комисс (НОК), Нийслэлийн Онцгой байдлын газар (ОБГ)-т шуурхай хүргүүлнэ.

9.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүүргийн Онцгой комисс, Онцгой байдлын хэлтэс хариуцан зохион байгуулж, жил бүр тодотгол хийнэ.

9.3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй, бэлэн байдлыг хангаагүйгээс үүдэн хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учирсан тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

---o0o---